



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/37

Дэлгэрмөрөн

**Засаг даргын нөөц хөрөнгөөс
хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам”-ийн 2.1.4, 2.1.5 дахь заалт, сумын Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрийг үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Сумын байгууллага иргэдээс сумын төвд золбин нохой олширч айлын мал барих, сургуулийн хүүхдүүд өглөө эрт хичээлд явах үед дайрч хүн бүр хүүхдүүдээ өөрсдийн биеэр хичээлд нь хүргэх хүнд нөхцөл байдал үүсээд байгаа, мөн хогийн жалгын хог хаягдал гялгар цаас сумын урд хэсгээр маш их талбайд тарж тухайн нутагт бэлчээрлэж байгаа мал цаас идэж бөөнтөж үхэх, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа зэрэг асуудлыг шийдвэрлэх зорилгоор золбин нохой устгалт, нийтийн хог цэвэрлэгээний ажлыг сумын хэмжээнд зохион байгуулсугай.

2.Золбин нохой устгалт, нийтийн хог цэвэрлэгээний ажил зохион байгуулахад зарцуулах бууны сум, хог хаягдал түүх иргэд, албан газар, аж ахуйн нэгж, ахлах ангийн сурагчдын амны хаалт, хамгаалах хэрэгсэл, ариутгалын бодисны үнэ болох 3000000 (Гурван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Нягтлан бодогч (Р.Мөнхбилэг)-т зөвшөөрсүгэй.

3.Анхан шатны санхүүгийн баримтыг бүрдүүлж тайлан тооцоог гаргаж ажиллахыг Нярав (Ц.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Баярсайхан)-д даалгасугай.

ДАРГА



С.СУМЪЯАБАЗАР

D:/Zahiramj-2022 on
642201073